



**АВТО ТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 5/84

Улаанбаатар хот

**Д.Жаргалсайханы хөдөлмөр эрхлэлтийн харилцааг
цуцлах сахилгын шийтгэл ногдуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.4, 80 дугаар зүйлийн 80.1.4, 123 дугаар зүйлийн 123.2.5 дахь хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 29 дүгээр зүйлийн 29.2.4 дэх заалт, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын дүрмийн 6.12, Хөдөлмөрийн дотоод журмын 3.18.1, 3.18.9, 5.1.1, 5.1.22, 11.6.1, 11.6.5, 11.6.24 дахь заалт, Авлигатай тэмцэх газрын 2022 оны 02 дугаар сарын 28 -ны 05/2775 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус үйлдвэрийн газрын Хөдөлгөөний удирдлагын хэлтсийн Хяналтын тасаг /Архангай аймгийн автотээврийн төв/ -ийн автотээврийн хяналтын мэргэжилтэн Д.Жаргалсайхан нь өөрийн үүсгэн байгуулсан зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч "Булган тээх" ХХК -ийн хот хоорондын нийтийн зорчигч тээвэрлэлтийн 2021 оны 4 дүгээр улирлын гэрээг 2022 оны 01 дүгээр сарын 10 -ны өдөр хангалттай гэж дүгнэн баталгаажуулах үйл явцад оролцсон нь өөрийнх нь гаргасан тайлбар болон холбогдох хууль хяналтын байгууллагын шалгалтаар тогтоогдож байгаа тул Хөдөлгөөний удирдлагын хэлтсийн Хяналтын тасаг /Архангай аймгийн автотээврийн төв/ -ийн автотээврийн хяналтын мэргэжилтэн Д.Жаргалсайханд 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөр тасалбар хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Д.Жаргалсайхантай санхүүгийн холбогдох тооцоог хийхийг Архангай аймгийн автотээврийн төвийн ахлах нягтлан бодогч /Ч.Мөнхжаргал/ -д, хариуцаж байсан эд хөрөнгө, ажлын баримт бичгийг акт тэмдэглэл үйлдэн 2022 оны 03 дугаар сарын 18 -ны дотор ажлыг нь хүлээн авахыг Архангай аймгийн автотээврийн төв /Б.Түмэнжаргал/-д тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

Б.ТҮРСОРОНЗОН

